



ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийг ажиглах хорооноос Пүрэв гарагт Хэвлэлийн бага хурал зарлаж байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглаж буй Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (АИХЭГ)-ын Сонгуулийг Ажиглах Хорооноос 6-р сарын 27-ны Пүрэв гарагт Улаанбаатар хотноо хэвлэлийн бага хурал зохион байгуулж, сонгуулийн дараах урьдчилсан мэдэгдлээ танилцуулах гэж байна. Мэдэгдлийг тус Хорооны дарга, элчин сайд, хатагтай Одри Гловер хийнэ.

Сонгуулийг ажиглах хороо нь 33 орны 210 ажиглагчаас бүрдэж байна. Энэхүү бүрэлдэхүүнд ЕАБХАБ-ын АИХЭГ-ын урт хугацааны 43 шинжээч, мөн тус байгууллагын хүсэлтээр гишүүн орнуудаас томилогдон ирсэн богино хугацааны 167 ажиглагч ажиллаж байна.

Хэвлэлийн бага хурал 6-р сарын 27-ны Пүрэв гарагийн 16:00 цагт Чингис хаан зочид буудлын хурлын танхимд болно. Сэтгүүлчид та бүхнийг Сонгуулийг Ажиглах Хорооноос зохион байгуулж буй хэвлэлийн бага хуралд хүрэлцэн ирэхийг урьж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг ЕАБХАБ/АИХЭГ-ын ажилтан Лорен Барановска-тай дараах хаягаар холбогдон авна уу.

Утас: 99315607, + 48 695 916 998

И-мэйл: lauren.baranowska@odihhr.pl